



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 58

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сайнцагаан сумын Хоёрдугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 318,746,56 /гурван зуун арван найман мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй барилга байгууламжийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сайнцагаан сумын Хоёрдугаар цэцэрлэгийн эрхлэгч (М.Туул)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг Сум байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлого 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
58 дугаар тогтоолын хавсралт



Хоёрдугаар цэцэрлэг актлах хөрөнгийн мэдээлэл

| №        | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо | Нэгжийн үнэ  | Балансын үнэ   | Хуримтлагдсан элэгдэл  | Үлдэгдэл өртөг | Актлах төрөл 1 устгах 2 худалдах 3 сэлбэг материал түүхий эд болгох 4 бусад |
|----------|---------------|------------------------|-------------|-----|--|--|--|----------------|---|
| 1        | Модон байшин  | 1980.01.01             | ш           | 1   | 100111.74  | 100111.74  | 100111.74  | -              | 1   |
| 2        | Ногоон склад  | 1981.01.01             | ш           | 1   | 218634.82  | 218634.82  | 218634.82  | -              | 1   |
| Нийт дүн |               |                        |             |     | <b>318746.56</b><br>/гурван зуун арван найман мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөг | <b>318746.56</b><br>/гурван зуун арван найман мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөг | <b>318746.56</b><br>/гурван зуун арван найман мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөг |                |   |